

ОХУ-ЫН УЛСЫН ХИЛ, ХИЛ ОРЧМЫН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ БОДЛОГО

*К.Дэмбэрэл**

ОХУ-ын хувьд хилийн орон зай нь онцгой чухал бөгөөд ач холбогдолтой зүйл. ОХУ-ын улсын хилийн нийт урт нь 60.9 мянган км бөгөөд түүний 38.8 мянган км нь усан замын хил бөлгөө. /22.1 мянган км хуурай газраар хиллэдэг/ Монгол Улс нь ОХУ-ын нийт хуурай замын хилийн 16%-ийг эзэлдэг. ОХУ-ын хилийн дагуухи субъектуудад 50 орчим үндэстэн, ястан оршин сууж хөрш улсуудтай хиллэдэг. ОХУ-ын Холбооны нийт 89 субъектын 45 нь хилийн бүсэд харьяалагддаг. ОХУ-ын хилийг 170 мянган хилчид, 25 мянган гаальчид манадаг.

“ОХУ-ын хилийн бодлогын үндэс” хэмээх албан баримтад “ОХУ-ын үндэсний сонирхол, аюулгүй байдалд тус улсын хилийн орон зайд гарч болох заналхийлэл” гэсэн тусгай бүлгийг оруулсан байдаг. Тэдгээрт хамгийн их аюултай гэсэн 11 заналхийллыг тусгасан байдаг. Ерөнхийлөгчийн зөвлөмжийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахад чухал үүрэгтэй “Аюулгүй байдлын зөвлөлийн Хилийн бодлогын яам дундын комисс”-ыг 1995 онд байгуулсан ба түүний бүрэлдэхүүнд 20 гаруй яам, газрын орлогч сайдын зиндааны хүмүүс багтдаг. Уг комиссын ажил үүргийн хуваарийг дараахи хэлэлцсэн асуудлын агуулгаас харж болно. Үүнд: 1996 оны 8 сард “Гаалийн Холбоонд оролцогч улсуудын гадаад хил дэх Оросын үндэсний сонирхлыг хамгаалах асуудлыг хангах арга хэмжээний тухай”, 1996 оны 12 сард “Улсын хилийн зүүн хэсэгт Оросын аюулгүй байдал, сонирхлыг хамгаалах тухай”, 1997 оны 6 сард “ОХУ-ын хилийн аюулгүй байдлыг хангах тухай”, 1998 оны 11 сард “ОХУ-ын улсын хилийг хууль бусаар нэвтрэхийг урьдчилан сэргийлэх тухай”, 1998 онд “ОХУ-аас ТУХН-ийн орнуудтай хилийн асуудлаар хамтран ажиллах тухай” гэх мэтийн олон асуудлыг удаа дараа хэлэлцэж байсан.

Олон улсын практикт хилийн худалдааны нөхцөл, дүрэм нь тухайн улсуудын явуулж буй гадаад, дотоод бодлогоор тодорхойлогдож ирсэн байдаг. ОХУ нь өнгөрсөн 200 жил улсын зүгээс хүчтэй протекционист бодлого явуулж ирсэн хэдий ч зах зээлийн эдийн засгийн харилцаанд орсноор худалдааг ихээхэн либеральчлан бүр ойрын жилүүдэд ДХБ-д элсэхээр зэхэж байгаа.

*К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

1. ОХУ-ын улсын хилийн бодлого

ОХУ-ын Улсын хилийн тухай хууль нь 1993 оны 4 сарын 1-нд батлагдсанаас хойш 2003 оныг хүртэл нийт 12 удаа нэмэлт өөрчлөлт хийгдэн 11 бүлэгтэй, 45 зүйлтэйгээр одоо үйлчилж байгаа. Энэ хуулиндээ улсын хилийн бодлогоо хуульчилсан.

ОХУ нь улсын хилийн шугамаа тогтоох, өөрчлөх, улсын хил дээр гадаад улс орнуудтай харилцаа тогтоох, өргөжүүлэх, улсын хилийн бүсийн эрх зүйн харилцааг зохицуулах зэрэг болон бусад асуудлыг шийдэхдээ дараахи үндсэн 4 зарчмыг баримтлахаар Улсын хилийн тухай хуулийн 1-р бүлгийн 2-р зүйлд заасан байдаг. Үүнд:

1. ОХУ-ын болон олон улсын аюулгүй байдлыг хангах,
2. Гадаадын улсуудтай бүх талын харилцан ашигтай хамтран ажиллах,
3. Улсын хилийн дархан байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх,
4. Хилийн асуудлыг /маргааныг/ энхийн замаар шийдэх

ОХУ нь хилийн бодлогоо “Холбооны болон орон нутгийн субъектуудын төрийн байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд, олон нийтийн байгууллага, иргэдийн зүгээс улс орныхоо тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн аюулгүй байдал, үндэсний сонирхлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хамгаалахад чиглэсэн болон улсын хилийн заагийг шударгаар тогтоох, тухайн улсын гадаад харилцааг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдсэн иж бүрэн үйл ажиллагаа мөн” хэмээн тодорхойлсон.

Аливаа улсын хилийн бодлогын үндэс нь тухайн улсын үндсэн хууль болон бусад нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн баримтууд байдаг.

Хилийн бодлогын үндсэн объектод дараахи зүйлүүд орно:

- ОХУ-ын улсын хил,
- Хилийн орон зай дахь ОХУ-ын үндэсний сонирхол ба ТУХН-ийн орнуудын гадаад хил дэх түүний сонирхол,
- Хилийн асуудлаархи улс хоорондын болон дотоодын харилцаа ба түүнээс үүдэн гарах эрх зүйн болон бусад төрийн зохицуулалт шаардсан зөрчил,

Хилийн бодлогын үндсэн субъект нь:

- Төр засгийн Холбооны байгууллагууд,
- ОХУ-ын субъектуудын төрийн төв байгууллагууд,
- Орон нутгийн байгууллагууд,
- Олон нийтийн байгууллагууд,

- Иргэд

Хилийн бодлогын зорилго бол ОХУ-ын үндэсний сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх, нийгмийн болон хувь хүн, төрийн аюулгүй байдлыг хил хязгаарын орон зайд хангах явдал.

Хилийн бодлогын үндсэн зорилтууд:

- ОХУ-ын тусгаар бие даасан байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, түүний хил хязгаарын аюулгүй байдлыг хангах нөхцлийг бий болгох,
- Улсын хилийг тогтоох олон улсын эрх зүйг боловсронгуй болгох,
- ОХУ-ын хилийн орон зайд аливаа мөргөлдөөн, хямрал, дайны аюулыг бий болгохгүй байх улс хоорондын хамтын ажиллагаа,
- Бусад улсын зүгээс ОХУ-ын газар нутаг руу хандсан эдийн засгийн болон хүн ам зүйн түрэлтийг сөрөн зогсох,

- ОХУ-ыг бусад улс орнууд, цэрэг улс төрийн эвслийн зүгээс ганцаардуулах гэсэн аливаа оролдлогыг таслан зогсоох,

- ОХУ-ын сонирхол, аюулгүй байдлыг олон улсын гэрээний үндсэн дээр ТУХН-ийн орнуудын гадаад хил дээр хангах,

ОХУ-ын хилийн бодлого хэд хэдэн үндсэн чиглэлээр хэрэгждэг:

- ОХУ-ын хилийн аюулгүй байдлыг хангах,
- Улс хоорондын хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- ОХУ-ын улсын хилийг тогтоох олон улсын эрх зүйг боловсронгуй болгох,
- ТУХН-ийн орнуудын гадаад хил дээр үндэсний болон хамтын аюулгүй байдлыг хангах,
- ОХУ-ын улсын хилийн бүсийн субъектуудын нийгэм-эдийн засаг, соёл, боловсролын хөгжилт,
- Хилийн бодлогын талаархи шинжлэх ухааны системтэй мэдлэгийг бий болгон хөгжүүлэх

2. ОХУ-ын хил орчмын бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал

ОХУ-ын Засгийн газар нь 2001 оны 2 сарын 9-ний өдрийн 196-р тоот удирдамжаар “ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагааны үзэл баримтлал”-ыг дараахи зүйлтэйгээр баталсан.

1. Ерөнхий зүйл.

2. ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагаанд Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагуудын тогтоогдсон хуулийн хүрээн дэх бүрэн эрхийн асуудал.

3. ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагааны чиглэл, төрөл.

4. Хил орчмын бүс нутгийн хөгжлийг дэмжих арга механизмууд

5. Хэрэгжилтийн асуудал

Дээрхи 5 зүйл бүхий үзэл баримтлал нь өнөөгийн ОХУ-ын нийт хилийн приметрийн дагуу орших бүх нутаг дэвсгэртээ явуулах үйл ажиллагаа, бодлогыг зохицуулах үндсэн баримт бичиг мөн тул үүний энэхүү 5 зүйлийн эхний 4-ийг нь арай дэлгэрэнгүй байдлаар авч үзье.

Ерөнхий зүйл буюу 1-р зүйлд Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд болон иргэдийн зүгээс хил орчмын хамтын ажиллагааны хүрээн дэх үйл ажиллагааны ерөнхий чиглэл, зарчим, зорилгыг тодорхойлсон. Ингэж тодорхойлохдоо түүхэн туршлага, бүс болон орон нутгийн сонирхол, тухайн орон нутгийн иргэдийн эрх ашгийг нийт улсын эрх ашигт нийцүүлэх талыг харгалзан үзсэн байна. Үзэл баримтлал нь ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагааны хөгжлийн асуудлаархи төрийн бодлогын үндсэн чиглэл, зорилтыг томъёолсон байна. ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагаа хэмээх ойлголт нь хоёр талын хил орчмын бүсийн тогтвортой хөгжлийн асуудлыг шийдэх, орон нутгийн хүн амын аж байдлыг дээшлүүлэх, ОХУ-аас хил залгаа улстайгаа тогтоосон хамтын ажиллагаа, сайн хөршийн болон найрамдалт харилцааг бэхжүүлэхэд чиглэгдсэн тус улсын Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагуудын зөвшилцсөн үйл ажиллагаа юм гэж тодорхойлжээ.

Хил орчмын хамтын ажиллагаа нь дараахи зарчмууд дээр үндэслэсэн байх ёстойг ч заасан. Үүнд:

1. Бусад улсуудын газар нутгийн бүрэн бүтэн байдал болон суверенитетыг харилцан хүндэтгэх,
2. Хилийн маргааныг энхийг замаар шийдэх,
3. Хилийн хамтын ажиллагааг явуулж буй орны болон олон улсын эрх зүйг харилцан хүндэтгэх,
4. Хилийн хамтын ажиллагаанд Оросын сонирхлыг хангах,
5. Хилийн хамтын ажиллагааг явуулж буй улсын эдийн засгийн болон бусад сонирхолд хохирол учруулахгүй байх,
6. Энэ хамтын ажиллагааг явуулахдаа ОХУ болон түүний хөршийн бүхий л онцлогийг харгалзан үзэх,
7. Үйл ажиллагаандаа 1980 оны Европын Ерөнхий Конвенцыг дагаж мөрдөх

Мөн энд хил орчмын бүсэд хамрагдах газар нутгийг бүхэлд нь зааж өгсөн. Гэхдээ эдгээр газар нутаг нь ОХУ болон түүний субъектуудаас тухайн оронтой тогтоосон олон улсын гэрээнд хэрхэн тусгагдсанаар

тодорхойлж болно гэсэн. Энэхүү хамтын ажиллагаанд оролцогчид нь Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагууд, аж ахуйн нэгж, хувь хүмүүс байж болно.

Хилийн хамтын ажиллагааны үндсэн зорилтууд нь гэвэл:

1. Хоёр орны хил орчмын бүсийн бүх түвшний субъектуудын хооронд итгэлцэл, харилцан ойлголцол, сайн хөршийн уур амьсгалыг бий болгох,

2. Мөн тэдгээрийн хоорондын аж ахуй, соёл, хүмүүнлэгийн харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх,

3. Хоёр талын нутгийн иргэдийн харилцан ойлголцол, найрамдлыг зузаатгах,

4. Хилийн хоёр талд буй үндэс нэгт ард түмнүүд, ажил хэргийхэн, төрийн байгууллагын харилцааг энгийн болгох,

5. Хил орчмын бүсэд нийгэм, эдийн засгийн үр ашигтай дэд бүтцийг хамтран байгуулж, хөгжүүлэх,

6. Хил орчмын бүсэд бий болсон эдийн засаг, тээвэр, холбоо, эрчим хүч, экологи, хүн ам зүй, хүмүүнлэгийн болон бусад бүхий л асуудлыг хамтран шийдэх,

7. Хил орчмын бүсийн асуудлыг шийдэхэд оролцож буй Оросын байгууллагуудад төр засгийн зүгээс дэмжиж туслах,

8. Хилийн бүсэд экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу, түргэн шуурхай нэвтрүүлэх боломжоор хангах,

9. Тухайн бүс нутаг дахь үйлдвэрлэлийн болон нийгмийн чиглэлийн бүхий л объектуудын ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх,

10. Хил дамнасан онц байдлаас бий болох аливаа зүйлийн сөрөг үр дагаврыг арилгах хамтарсан үр ашигтай системийг байгуулах нөхцлийг бүрдүүлэх,

11. Стратегийн ач холбогдол бүхий болон хүн ам цөөтэй хилийн бүсээс хүн амын шилжих хөдөлгөөнийг багасгах нөхцлийг бүрдүүлэх,

12. Энэ бүсэд их гүрний дээрэнгүй үзэл, үндэсний үзэл, үндэсний болон шашны салан тусгаарлах үзэл, угсаатан хоорондын зөрчил, дайсагнал, түгшүүртэй байдлыг гаргуулахгүй байх,

13. Үндэсний аюулгүй байдал, үндэсний сонирхлыг хангахад чиглэсэн ОХУ-ын дотоод, гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх,

ОХУ, түүнтэй хил залгаа улсуудтай хилийн хамтын ажиллагааг явуулахдаа Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагууд нь тухайн бүсийн хоёр талын

онцлогийг тодорхойлсон дараахи хүчин зүйлүүдийг харгалзан үзэх ёстой аж. Үүнд:

1. Тус хөрш улсаас ОХУ-тай тогтоосон харилцаа, нэн ялангуяа цэрэг-улс төрийн харилцааны ерөнхий шинж,
 2. Хоёр улсын хилийн бүсэд оршин суугаа ард иргэдийн түүхэн уламжлал, харилцааны хэлбэр, ёс заншил, зан үйл,
 3. Байгалийн нөөц, нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын нөхцөл,
 4. Бүс дундын эдийн засгийн хоршилтод хилийн бүсийн хамтын ажиллагааны нөлөө, түүний шинж,
 5. Хилийн бүсэд нийгмийн дэг журмыг сахиулах ОХУ-ын нийтлэг журам,
 6. Үндэстэн-угсаатны бодлогын хүчин зүйлүүд,
 7. Хилийн бүсийн байгалийн нөөц баялгийг хянах улсын нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх онцлог,
 8. Хилийн бүсийн нийгмийн үйл явцад хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөө,
 9. Хил дамнасан онц байдал үүсэж болох байгалийн хүчин зүйл,
 10. Уг бүсэд ОХУ-ын үндэсний аюулгүй байдлаа хангах онцлог,
- Хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, төрлийг сонгохдоо дээрхи онцлогуудыг зайлшгүй харгалзахыг энэхүү үзэл баримтлалд заасан.

2. ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагаанд Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудын Гүйцэтгэх Засаглал, орон нутгийн байгууллагуудын тогтоогдсон хуулийн хүрээн дэх бүрэн эрхийн асуудал

Энэ асуудлыг зааглан ангилж өгсөн нийт 7 хууль, /Үндсэн хуулийг оруулахгүйгээр/ Холбооны Засгийн газраас субъектуудтай тогтоосон гэрээнүүд байдаг юм байна. Өөрөөр хэлбэл, хил орчмын хамтын ажиллагаанд оролцох субъектуудын үйл ажиллагааны хүрээг нарийвчлан тогтоосон.

Олон улсын болон гадаад эдийн засгийн харилцааны салбарт бүрэн эрхийг нь ангилах тухайд:

1. Хил орчмын бүсийн хамтын ажиллагааг зохицуулах салбарт Холбооны гүйцэтгэх засгийн эрх мэдэл юу вэ?
 - олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах
 - хил орчмын бүсийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт тусгагдах ёстой үндсэн шаардлагыг тогтоох
 - хил орчмын бүсийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх журмыг тогтоох

- ОХУ-ын Гаалийн тарифыг хэрэглэх дэг журмыг тодорхойлох
- ОХУ-ын хилийн бүсэд гадаад эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах

- хил орчмын бүсийн хамтын ажиллагааны асуудлаар ОХУ-ын сонирхлыг олон улсын байгууллагад танилцуулах

2. Хил орчмын бүсийн хамтын ажиллагааг зохицуулах салбарт Холбооны гүйцэтгэх засаглал, субъектуудын гүйцэтгэх засаглалын хамтран хэрэгжүүлэх эрх мэдэл юу вэ?

- ОХУ-ын субъектуудын олон улсын болон гадаад эдийн засгийн харилцааг зохицуулах, олон улсын гэрээг биелүүлэх

- хил орчмын бүсийн хамтын ажиллагааг зохицуулах асуудлаар субъектуудын үйл ажиллагааг зохицуулж байх

- хилийн бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны журмыг тогтоох

- хил орчмын бүсийн хамтын ажиллагааны асуудлаархи Холбооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

3. ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын бүрэн эрхийн хэмжээ

- эрх мэдлийн хүрээнд хил залгаа улсын засаг захиргааны нэгжтэй хэлэлцээр хийх, тогтоосон журмын дагуу хилийн бүсийн хамтын ажиллагааны талаар зөвшилцөө хийх

- хилийн бүсэд аж ахуйн үйл ажиллагаа явуулах журмыг тогтоох талаар санал боловсруулах

4. Орон нутгийн байгууллага нь өөрийн эрх мэдлийн дараах эрхтэй.

- хил залгаа улсын засаг захиргааны ижил түвшний нэгжтэй гадаад эдийн засгийн үйл ажиллагааг тогтоосон журмын хүрээнд явуулах

- тогтоосон хуулийн хүрээнд гадаадын түншүүдтэй хэлэлцээ хийх

3. ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагааны чиглэл, төрөл

Хилийн хамтын ажиллагаа нь дараах хэлбэрээр хэрэгжих юм. Үүнд:

- хилийн хамтын ажиллагааны асуудлаар төрийн эрх бүхий байгууллагуудын уулзалтыг зохион байгуулах,

- төрийн эрх бүхий байгууллагууд хилийн хамтын ажиллагааны асуудлаар хамтарсан зохицуулах байгууллага мөн ажлын хэсгийг байгуулах,

- ОХУ-ын хилийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг гадаад улстай, ОХУ-ын субъектуудтай болон аливаа гадаад улсын засаг захиргаанутаг дэвсгэрийн нэгжүүдтэй эсвэл гадаад улсын төр засгийн байгууллагуудтай тогтоосон журмын хүрээнд хийх,

- Орон нутгийн байгууллагууд нь Оросын хуулийн этгээд болон гадны түншүүдтэй хилийн хамтын ажиллагааны тухай иргэний эрх зүйн гэрээг хийх,

- Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техникийн Засгийн газар хоорондын Комиссын хүрээнд хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хэсэг байгуулах,

ОХУ нь түүний бусад хууль тогтоомжид харшлахгүй улс орныг түүний бүс нутгийг хөгжүүлэх зорилгод нийцсэн хилийн хамтын ажиллагааны бусад хэлбэрийг ашиглаж болно. Хил орчмын бүсийн хамтын ажиллагааны хөгжилд үйл ажиллагааны дараах чиглэлүүдийг явуулахыг удридамжид зөвлөсөн байдаг.

1. Хилийн бүсэд аж төрдөг иргэд нь өөрсдийн хэрэгцээг хангах үүднээс хөрш улсын хилийн бүсэд аж төрдөг иргэдтэй хил худалдааны маягаар хамтран ажиллах,

2. Хөрөнгө оруулалт, техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах, /хамтарсан үйлдвэр, харилцан мэдээлэл солилцох, аж ахуйн нэгжүүдийн хооронд байнгын харилцааг тогтоох г.м/

3. Бусад улсаас ОХУ-д оруулах ХАА, МАА-н бүтээгдэхүүний чанарын баталгаажилтанд тус улсад оруулах бараанд тогтоосон стандарт, хэм хэмжээ, шаардлагад нийцсэн нэгдмэл шаардлагыг боловсруулах,

4. Ариун цэвэр хорио цээрийн хяналт, хилийн бүсийг малын халдварт өвчнөөс хамгаалах асуудлыг шийдэх, мал тууварлах, малын гаралтай бүтээгдэхүүн оруулахад аюулгүй байдлыг хангах шаардлагыг нэгдмэл болгох,

5. Хилийн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны судалгааг явуулах,

Тээвэр, холбооны салбарт хамтын ажиллагааны дараахи чиглэл, хэлбэрүүдийг дэмжсэн байдаг. Үүнд:

1. Хилийн бүсийн нутаг дэвсгэрт бүх төрлийн тээврийн үйл ажиллагаа саалгүй явагдах зайлшгүй нөхцлийг бүрдүүлэхэд нөлөө үзүүлэх,

2. Нийтлэг шаардлагыг судлах үндсэн дээр тээврийг хөгжүүлэх хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлэх,

3. Тээврийн асуудалтай холбоотой мэдээлэл солилцох ажиллагааг явуулж байх,

4. Бүх төрлийн мэдээллийн сүлжээг хамтран хөгжүүлэх,

5. Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах, хүрээлэн буй орчныг хамгаалах талаар хамтран ажиллах,

6. Хил дамнасан ашигт малтмалын орд, усны нөөцийг хамтран ашиглах,

7. Хил орчмын бүс нутагт хууль сахиулах байгууллагуудын хүрээнд хамтран ажиллах,

8. Шинжлэх ухаан болон хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах,

4. Хил орчмын бүс нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээнүүд

Хил орчмын бүс нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээ нь тухайн бүс нутгийн болон Оросын нийт хүн ардын нийтлэг сонирхлыг тусгахын зэрэгцээ хиллэж буй нөгөө улсын хилийн бүсийн хүн ардын эрх ашгийг харгалзан үзэх замаар явагдахын чухлыг заасан байдаг. Ингэхдээ:

- хил орчмын хамтын ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх
- хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх,

- хил орчмын хамтын ажиллагааны асуудлаархи ОХУ-ын хууль дүрмийг хиллэж буй улсын хууль дүрмэнд аль болох ойртуулж зохицуулахаар ажиллах,

- ОХУ, түүний субъектуудын зүгээс хиллэж буй улстай тогтоосон эдийн засаг, нийгэм, соёл, захиргааны болон бусад харилцаа холбоог бэхжүүлэх,

- ОХУ-ын төмөр замын тарифыг хэрэглэх журмыг тодорхойлох,

- Орон нутгийн татварын хэмжээг зохицуулах,

- Хил орчмын хамтын ажиллагааны хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж буй орон нутгийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

- Энэ бүс нутагт оршин сууж үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд хил, гаалийн хяналтын журмыг боловсронгуй болгох арга хэмжээ авах,

Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудын гадаад хилийг хамгаалахад хамтран ажиллах тухай гэрээг 2003 онд Беларусь, Казахстан, Кыргызстан, ОХУ, Тажикстан улсын тэргүүн нар Москва хотноо үзэглэсэн. Энэхүү гэрээ, түүний хавсралтуудыг үзэхэд эдгээр улсууд нь цэрэг-батлан хамгаалах салбарт нэгэн эвсэл болсон аж. Бидний хувьд энэхүү гэрээ нарийн судлаад, хэрэгжилт нь ямар механизмаар явагдаж буйг нь ажиглаж байх нь чухал.

Орос-Хятадын хооронд хил тогтоогоод 300 гаруй жил болж байгаа хэдий ч өнөө болтол эцэслэн шийдэгдээгүй байгаа. /Зүүн талдаа 2 голын хамаарлын асуудал үлдээд байгаа/ Энэ хил нь зүүн талдаа 4325 км газраар, баруун талаараа 55 км газраар тус тус хиллэдэг. Эдгээр хоёр хөрш маань зөв зохистой хилээ олон улсын гэрээ хэлэлцээрээр

баталгаажуулах нь Монголд чухал. Учир нь зохих ёсоор баталгаажуулах хилтэй хоёр улсын хооронд орших бидэнд ч гэсэн элдэв сөрөг нөлөө нь тусах магадлалтай. Мөн хоёр улсын хиллэж буй бүс нутаг нь нийгэм, эдийн засгийн хувьд сул хөгжилтэй бүс нутаг хэмээн санал нэгтгэй үздэг. Тэгвэл тэдгээрийн хоцрогдсон бүстэй хаяа нийлэн орших буурай хөгжилтэй Монгол Улсын хөгжлийг аль зүгт чиглүүлэх вэ?

ОХУ-ын Холбооны Хилийн алба нь Эрүүлийг хамгаалах, Дотоод, Тээврийн, Татварын, ХАА-н яамд, Гааль, Аюулгүй байдлын, Татварын цагдаа гэсэн улсын хороодтой үйл ажиллагаагаа нягт уялдуулах захирамжтай байдаг. /тухайбал, SARS-ын үед/

ОХУ нь нийт 16 улстай хиллэдэг ба тэдгээрээс зөвхөн Норвеги, Финлянди, БНАСАУ, Монгол, Польш гэсэн 5 улстай л хилийн асуудлаа олон улсын эрх зүйн хэм хэмжээнд зохицуулсан ба бусад 11 улстай хилийн маргаантай гэсэн үг.

1913 онд Оросын эзэнт улсын хилийг 12 сая хүн нэвтэрч байсан бол Зөвлөлт засгийн үед жил тутам 2 сая хүн нэвтэрч байсан. Харин өнөө үед жилд дунджаар 80 сая хүн, 12 сая тээврийн хэрэгсэл улсын хилийг зорчиж байна.

ОХУ-ын улсын хил дээр нийт 460 ШНП ажилладаг ба эдгээрээс 12 нь өөр улсын нутаг дэвсгэрт оршдог.

ОХУ нь хуучин Зөвлөлийн бүрэлдэхүүнд байсан БНУ-ын одоогийн ОХУ-тай хиллэж буй хил хязгаарын асуудалд онцгой анхаарал хандуулж байгаа.

ДҮГНЭЛТ

1. Хөрш орнуудын хилийн бодлого, хил орчмын бүс нутгаа хөгжүүлэх талаар явуулж буй бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайтар судлан Монгол Улсын хилийн бодлого, бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалд тусгаж байх.

2. Хилийн шалган нэвтрүүлэх постуудад албан хаагчдын мэргэжлийн болон хэлний боловсролд түлхүү анхаарах,

3. Хилийн болон хил орчмын бүс нутгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулж буй аж ахуйн нэгж, пүүс, хувь хүмүүст төрийн зүгээс бодлогоор дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бүрдүүлэх,

4. Хилийн орчмын бүс нутгийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд Засгийн газар, орон нутгийн төрийн байгууллагуудын эрх мэдлийг зөв тогтоон хуулиар баталгаажуулах,

5. Хилийн бүсийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн болон бусад асуудлаар тодорхой хугацаанд /2-3 жил тутамд/

нарийвчилсан судалгааг явуулж үр дүнг нь хилийн бүсийн хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо ашигладаг байх,

6. Хилийн бодлого, хил орчмын бүс нутгийн хөгжлийн асуудалд холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдааг улам сайжруулах шаардлагатай.

Эцэст нь хэлэхэд, бидний хэлэлцэж буй хил, хязгаар түүний хөгжлийн асуудал аль ч улсын хувьд тун эмзэг асуудал тул хэн ч сэтгэлийн хөөрлөөр шийдэх эрхгүй байдаг. Энэ үүднээс ОХУ-ын Төрийн Дум нь улс төрийн олон хүчнүүд нэгдсэн олон ургальч үзлийн “уралдааны” төв гэдэг утгаараа улсын хилийн бодлого, хил хамгаалалтын асуудал, визийн асуудал, цагаачдын асуудал, үндэсний сонирхлын асуудал, хилийн бүсийн хөгжлийн асуудлаар өөр өөрсдийн байр сууриа илэрхийлдэг улс төрийн тэмцлийн талбар тул Дум дээр хэлэлцэгдсэн асуудал бүрийг нарийн, тухайлбал эмзэглэн хүлээн авах шаардлагагүй билээ.

Хавсралт №1**Орос-Хятадын хилийн худалдааны талаар сонирхуулахад**

Бүр 1988 онд ЗХУ бартерийн арилжааг бүх төрлийн татвараас бүрэн чөлөөлсөн. 1986 онд БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан “Хойд бүсээ нээлттэй болгох, өмнөд бүсээ холбоотой болгох” курсын хүрээнд Оростой хиллэдэг зарим хотууд нээлттэй болж чадсан. Бартерийн арилжаа нь хилийн худалдаанд анхандаа илүү тохиромжтой байсан. Орос-Хятадын хилийн худалдаа 1992 онд гэхэд 4 тэрбум ам.долларт хүрч байсан ба түүний 90% бартерийн арилжаа байлаа. Техник-эдийн засгийн хамтын ажиллагаа ч гэсэн бартераар хийгдэж байлаа. 1993 оноос хоёр тал энэ төрлийн арилжааг хязгаарлах болсон ба 1990-ээд оны сүүлээс ОХУ-ын зүгээс “ганзагын” наймааг хязгаарлах болсон. 2000 оноос Орос нь Хятадтай ганзагын наймаанд үйлчилдэг байсан ШНП-ын тоог цөөлсөн. 1998 оны 1 сард хилийн болон бүс хоорондын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны Орос-Хятадын зохицуулах зөвлөл байгуулагдсан. Хоёр улсын хоорондын хамтын ажиллагааны хэтийн чиглэл нь 2001 онд байгуулсан “Сайн хөрш, найрамдал, хамтын ажиллагааны тухай” гэрээнд тусгагдсан.

Хил орчмын бүсийн харилцааг өргөжүүлэх бас нэгэн алхам бол хилийн ШНП-ын тоог нэмэгдүүлж тэдгээрийн үйл ажиллагаагаа зохих хэмжээнд явуулах нөхцлийг бүрдүүлэх явдал. Оросуудын хувьд 1993 онд гэхэд гаалийн импортын татвараа нэмэх, мэтээр чанаргүй бараа орж ирэхийг хориглосон, шахсан бодлого барьснаар Хятадын зүгээс барааны чанарт анхаарах, татварын хэмжээг эргэн харах мэтээр ажиллахад хүргэсэн.

ОХУ-ын хил орчмын бүс нутагт Холбооны төвөөс зөвхөн ШНП, тэдгээрийн замын сүлжээг сайжруулах чиглэлд бага зэргийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан ба хилийн бүсэд хөрөнгө оруулалтыг идэвхижүүлэх талаар ямар ч арга хэмжээ авч байсангүй. Энэ нь Монголтой холбоотой бүх боомтууд дээр ажиглагдаж байсан.

1999 оны 1 сараас модны импортын татварыг тэглэсэн. Тэр нь Оросоос жил тутам бараг 6 сая куб.метр /1995 онд 0.35 сая куб.м, 2000 онд 6 сая куб.м/ мод импортлож хил орчмын бүсэд мод боловсруулах олон тооны үйлдвэрүүд байгуулагдахад хүргэсэн.

Хил орчмын бүс нутгийг хөгжүүлэхээр Хятадуудын эхэлж буй дараагийн алхам бол “Олон улсын чөлөөт бүс” буюу хилийн хоёр талын хотыг хосоор нь хөгжүүлэх бодлого билээ. Энэ чиглэлээр “хамтдаа хөгжье” хэмээх бодлогыг тунхагласан. Гэхдээ энэ нь чухам аль бүс нутгийн аль

зах зээл рүү хандах вэ гэдгээс ихээхэн хамааралтай. Тиймээс СУАР-д ихээхэн найдлага тавьж анхаарах боллоо. Учир нь тэрээр Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн гишүүн орон болох Казахстан, Кыргызстан, Тажикстантай шууд хиллэж, ОХУ-ын Баруун Сибирьт шууд гарах боломжтой төдийгүй, Европ хүрэх хамгийн дөт замтай гэдэг талаасаа хамгийн сонирхол татсан хил орчмын бүс нутаг яах аргагүй мөн. ШХАБ-аар дамжуулан СУАР-ны хөгжлийг нэмэгдүүлэх бодлогыг барьж байгаа.

Хавсралт №2

Чөлөөт бүсийн үндсэн загварууд: хөнгөлөлтийн бүтэц
ба хэлбэр хэмжээ

Чөлөөт бүсийн төрөл	Хэмжээ /хав.дөр. км/	Гаалийн хил байх эсэх	Үндсэн хөнгөлөлт үүд	ЭЗЧБ-ийн дэлгэрсэн гол бүс, нутаг, улс орнууд
Чөлөөт худалдааны бүс	3-5 хүртэл	Зайлшгүй шаардлагатай	гаалийн	Хөгжиж буй болон хөгжилтэй орнуудын тээврийн томоохон зангилаанууд
Аж үйлдвэр - үйлдвэрлэлийн: 1) Тодорхой чиглэлийн	1-2 хүртэл	Байхгүй	Гаалийн	Бразил, Мексик, Пуэрто-Рико, Филиппин, Карибын сав газар,
2) Аж үйлдвэрийн парк	0,1-0,5 1-20	Зайлшгүй биш	гаалийн	ЗӨА, Мексик
Үйлдвэрлэл-худалдааны	1-4	Зайлшгүй шаардлагатай	гаалийн	АНУ
Жижиг бизнесийн бүс	0,01-3	Байхгүй	Санхүүгийн болон татварын	Энэтхэг, Ойрхи Дорнод, Аргентин, Франц, ЗӨА
ШУ, үйлдвэрлэлийн	2-20	Зайлшгүй биш	татварын	ЗӨА-ийн ШАҮО
Санхүүгийн офшор төвүүд	0,05-0,1	Байхгүй	татварын	Карибын сав газар, Гонконг, Сингапур
Иж бүрэн: 1) эдийн засгийн тусгай бүс	16-330	Зайлшгүй	гаалийн татварын Санхүүгийн	БНХАУ
2) эдийн засгийн онцгой дэглэмтэй газар нутаг	2 200 000	Заримд нь зайлшгүй	гаалийн татварын Санхүүгийн	Бразил, Аргентин
3) Эдийн засгийн онцгой бүс	Захиргаа-нутаг дэвсгэрийн хүрээнд	Зарим нутаг дэвсгэрт зайлшгүй	гаалийн татварын Санхүүгийн	ОХУ, Калининград

Хавсралт №3

№	ОХУ-ын субъектууд	Хүн ам, /мөн.хүн/ түүний бүтэц	Газар нутаг, /мөн.хав.дөр.км/	ДНБ тэрбум рубль	Эдийн засгийн ерөнхий төлөв	Монгол Улстай харилцах харилцааны төлөв
1	БН Алтай улс	204.8 хүн амтай, оросууд-60% алтайчууд-31% казахууд-5.6% нийт хүн амын 47.6% нь эрэгтэй, 52.4% эмэгтэйнүүд	92.9 нутагтай бөгөөд ОХУ-ын газар нутгийн 0.55% болж байна.	8.8	Хүнс, ХАА салбар харьцангуй хөгжсөн, ноолуурыг ЗӨА-ийн зах зээлд гаргадаг.	Гадаад худалдааны 45% нь Монголтой
2	БН Буриад улс	1034.8 хүн амтай, оросууд-67.8% буриадчууд-27,8%	351.3 нутагтай.	50	Аж үйлдвэрийн салбар, нэн ялангуяа түлш-эрчим хүчний салбар АҮНБ-ний 60%-ийг үйлдвэрлэдэг ба жилд 4 тэрбум квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг. Ашигт малтмалын 600 гаруй орлыг нээн ашиглаж байгаа.	Нийт экспортын – 10.4%, импортын – 14.4% нь Монголд ноогдоно.
3	БН Тыва улс	311.4 хүн амтай, нийт хүн амын 2/3 буюу 77% нь тывачууд, оросууд-20,1%	170.5 нутагтай,	8.6	ХАА нь салбарыг голлон хөгжүүлж ирсэн. Икэнхи хэрэглээгээ импортгоор хангадаг	Гадаад худалдааны 99% нь Монголтой.
4	Чита муж	1274 хүн амтай ба нийт хүн амын 88.4% нь оросууд, 4.8% нь буриадчууд.	431.5 нутагтай ба түүнд нь 79 нутагтай Агийн Буриадлын автономит тойрог багтдаг.	-	Аж үйлдвэр, тээврийн болон ХАА-н салбар адил тэнцүү хөгжсөн. Орос-Хятадын нийт бараа эргэлтийн 60%-нь түүний нутаг дэвсгэр дээрхи Забайкалск боомтоор хийгддэг.	-